



Food and Agriculture
Organization of the
United Nations



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ХУРИМТЛАЛЫН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГО, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ЗАРДЛЫН ДУНД БОЛОН УРТ ХУГАЦААНЫ ТООЦООЛЛЫН ТАЙЛАН

ХУРИМТЛАЛЫН НЭГДСЭН САНГИЙН ТООЦООЛОЛ

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

Тооцооллын тайлан төслийг боловсруулсан:

Б.Оюун - Актуарч

ТУС ХЭВЛЭЛИЙГ ЗӨВХӨН ДОТООДЫН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАН БЭЛТГЭВ.

Энэхүү Хуримтлалын нэгдсэн сангийн “Орлого, хөрөнгө оруулалт, зардлын дунд болон урт хугацааны тооцооллын тайлан”-г “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд боловсруулав. Төслийг Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Европын Холбоо бол Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Тус Холбоо нь хүний эрхэм чанар, эрх чөлөө, ардчилал, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг түүний дотор цөөнхийн эрхийг дээдлэх үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлан байгуулагджээ. Өнөө цагт Европын Холбоо нь даян дэлхийн хүн бүрд хүртээмжтэй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

7	Ажлын даалгавар
7	I. Хуримтлалын нэгдсэн сангийн орлогын тооцоолол
7	Арга зүй
7	Тоон мэдээлэл болон холбогдох таамгууд
8	Монгол Улсын хүн ам
8	Төрөлт
10	Нас баралт
10	Шилжилт хөдөлгөөн
11	Хүн амын тооцооны үр дүн
12	Макро эдийн засгийн хүрээ
12	Ажиллах хүч
14	Инфляц, хөдөлмөрийн бүтээмж болон цалингийн өсөлт, Дундаж цалин
15	Сайн дураар даатгуулагчдын дундаж шимтгэл
15	Сангийн бусад орлого
15	Халамж болон тэтгэмжийн орлого
15	Татварын орлого
16	Үр дүн – Бүтээгдэхүүн 1
18	II. Хуримтлалын нэгдсэн сангийн хөрөнгө оруулалтын дунд болон урт хугацааны таамаглал
18	Хөрөнгө оруулалтын бодлого
18	Бодлогын хүүний таамаглал
19	Хөрөнгө оруулалтын үр дүн – Бүтээгдэхүүн 2
21	III. Хуримтлалын нэгдсэн сангийн зарлагын дунд болон урт хугацааны таамаглал
21	Арга зүй
21	Ипотекийн урьдчилгаа
24	Түрээсийн орон сууц
25	Боловсрол
26	Эрүүл мэнд
28	IV. Нэмэлт тооцоолол
28	ХНС-ийн орлогын хувийн өөрчлөлтийн харьцуулалт
32	Шинэ оролцогч нарыг Бүрэн ХНС-д оруулах хувилбарын харьцуулалт
38	Төрийн албан хаагчдын цалингийн өсөлт болон урамшуулал
38	Үр дүн – Бүтээгдэхүүн 3
42	V. Дүгнэлт

ЗУРАГЛАЛЫН ЖАГСААЛТ

- 8 Зураглал 1 - МУ хүн ам насны бүлгээр, 2022 - ҮСХ
- 9 Зураглал 2 - Төрөлт
- 10 Зураглал 3 – Нас баралтын түвшний хувилбарууд
- 12 Зураглал 4 - Хүн амын төсөөлөл
- 13 Зураглал 5 - Хүн ам зүйн ачаалал
- 14 Зураглал 6 - Эдийн засгийн үзүүлэлтүүдийн бодит дүн болон таамаг
- 15 Зураглал 7 - Тэтгэмжийн орлогын таамаг
- 16 Зураглал 8 - НӨАТ буцаан олголт
- 17 Зураглал 9 - ХНС орлогын хэмжээ /хөрөнгө оруулалт болон зарцуулалт ороогүй/
- 18 Зураглал 10 - Бодлогын хүү болон инфляц
- 19 Зураглал 11 - Бодлогын хүүний таамаглал
- 22 Зураглал 12 - Даатгуулагчийн тоо - таамаг
- 22 Зураглал 13 - Орон сууцны үнийн мэдээ 2023 - ҮСХ
- 23 Зураглал 14 - Ипотекийн зээлд хамрагдсан орон сууц талбайн хэмжээгээр
- 23 Зураглал 15 - Ипотекийн зээлд хамрагдсан иргэдийн тоо - ҮСХ
- 29 Зураглал 16 - Шимтгэлийн хувийн хувилбаруудын харьцуулалт
- 32 Зураглал 17 - Даатгалын шимтгэлийн хуваарилалт - хувилбар А /тэрбум төгрөг/
- 34 Зураглал 18 - Даатгалын шимтгэлийн хуваарилалт - хувилбар В /тэрбум төгрөг/
- 35 Зураглал 19 - Даатгалын шимтгэлийн хуваарилалт - хувилбар С /тэрбум төгрөг/
- 36 Зураглал 20 - Даатгалын шимтгэлийн хуваарилалт - хувилбар D /тэрбум төгрөг/

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

9	Хүснэгт 1 - Төрөлтийн коэффициент 2013-2022
9	Хүснэгт 2 - Төрөлтийн коэффициентын таамгууд
10	Хүснэгт 3 - Төрөлтийн тоо, хүйсийн харьцаа 2013-2022
10	Хүснэгт 4 - Нас баралтын түвшний хувилбарууд
11	Хүснэгт 5 - Гадагшаа шилжих хөдөлгөөний урсгал
11	Хүснэгт 6 - Хүн амын хэтийн тооцоолол
11	Хүснэгт 7 - Хүн амын тооцоолол - 2023-2028
12	Хүснэгт 8 - Хөдөлмөр эрхлэлтийн түвшний таамаг
14	Хүснэгт 9 - Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэдийн тоо
14	Хүснэгт 10 - ДНБ-ийн өсөлт, инфляцийн таамаг
16	Хүснэгт 11 - НӨАТ-ын буцаан олголтын таамаг
19	Хүснэгт 12 - Хөрөнгө оруулалтын үр дүн
24	Хүснэгт 13 - Түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамрагдах таамаг
25	Хүснэгт 14 - Боловсролын зардал болон хамрагдах таамаг
27	Хүснэгт 15 - Эрүүл мэндийн эмнэлэг, тусламжийн үйлчилгээний статистик
27	Хүснэгт 16 - ЭМ-ийн зарцуулалтын эрх үүсэх таамаг
29	Хүснэгт 17 - Шимтгэлийн хувилбаруудын харьцуулалт, дүнгээр, 2024 онд 18 настай байр иргэний хувьд
32	Хүснэгт 18 - Хувилбар А
34	Хүснэгт 19 - Хувилбар В /тэрбум төгрөг/
35	Хүснэгт 20 - Хувилбар С /тэрбум төгрөг/
36	Хүснэгт 21 - Хувилбар D /тэрбум төгрөг/
38	Хүснэгт 22 - ХНС-аас тэтгэврийн зарцуулалт
39	Хүснэгт 23 - 35 настай иргэний хуримтлалын хуваарилалт

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1 – ХНС-ийн хөрөнгө оруулалт, зарцуулалт тооцоогүй орлогын таамаг

Хавсралт 2 - ХНС-ийн хөрөнгө оруулалтын үр дүн

Хавсралт 3 – Нэг даатгуулагчийн хуримтлалын хөрөнгө оруулалтын үр дүн

Хавсралт 4 – ХНС –ийн зарцуулалт

Хавсралт 5 - Нэг даатгуулагчийн хуримтлалын зарцуулалтын тасаг

* Тайлангийн агуулга нэмэлт тооцооллуудтай холбоотойгоор бүтээгдэхүүн 1-ийн тайлангаас бага зэрэг өөрчлөгдсөн байх боломжтой.

АЖЛЫН ДААЛГАВАР

Хуримтлалын нэгдсэн сан (ХНС)-ийн орлого, хөрөнгө оруулалт, зарлагын тооцооллыг тус бүрийг

- a) Хуримтлалын нэгдсэн сангийн түвшинд
- b) Өрх
- c) Хувь хүнээр

Гэсэн таамаглалын тооцоолол хийж 3 бүтээгдэхүүн боловсруулна:

1. Бүтээгдэхүүн 1 – ХНС-ийн орлогын дунд (5 жил) болон урт хугацааны (60 хүртэл жил) актуар тооцоолол

2. Бүтээгдэхүүн 2 - Хуримтлалын нэгдсэн сангийн хөрөнгө оруулалтын дунд болон урт хугацааны тооцоолол хийх

- a. Хөрөнгө оруулалтын өгөөж, алдагдлын тооцоолол
- b. Гэр бүлийн гишүүдийн тооны өсөлт, гэр бүлийн орлогын таамаглал
- c. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, цалингийн өсөлтийн таамаглал
- d. Нийгмийн даатгалын хамралтын таамаглал
- e. Хүүгийн өсөлтийн таамаг
- f. Портфолио модел гаргах

3. Бүтээгдэхүүн 3 - Хуримтлалын нэгдсэн сангийн зарлагын дунд болон урт хугацааны таамаглал

- a. Эрүүл мэнд
- b. Боловсрол
- c. Орон сууц
(ипотекийн урьдчилгаа болон түрээсийн орон сууц гэсэн хувилбар нэмэгдсэн)
- d. Тэтгэвэр

Тооцооллыг динамик хэлбэрээр буюу голлох үзүүлэлтүүдийг хувьсах байдлаар харгалзан тооцох боломжтойгоор хийсэн болно. Үүнд загварын эхний “Таамгууд” хуудаст хувьсах үзүүлэлтийг өнгөөр тодруулж, холбогдох үр дүнг дээр дурдсан 3 түвшнээр жил тус бүрийн орлого, хөрөнгө оруулалт болон зарцуулалт бүлгээр өссөн дүнгээр “Үр дүн” хуудаст хүснэгтээр оруулсан.

I. ХУРИМТЛАЛЫН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ТООЦООЛОЛ

АРГА ЗҮЙ

ХНС-ийн дансны орлого нь заавал буюу тэтгэврийн даатгалын шимтгэлд төлөх 2% / явцын дунд энэ тоо өөрчлөгдөх боломжтойгоор загварт оруулсан/, сайн дурын буюу төрөөс иргэдэд орлогын дэмжлэг, халамж хэлбэрээр олгодог олговор болон татварын буцаан олголтуудаас бүрдэнэ гэж авч үзсэн.

Сангийн орлогыг нийт нийгмийн даатгуулагчдын тоо, даатгуулагч бүрээс төлөгдөх шимтгэл болон нэмэлт орлогын тооцоололд үндэслэн тооцсон, өөрөөр хэлбэл хүн амын болон эдийн засгийн богино болон урт хугацааны төсөөлөл гаргаж, үр дүнд сангийн орлогын хэмжээг тооцоолсон болно.

Хүн амын тооцооллыг Cohort component projection буюу хүн амын төрөлт, нас баралт болон шилжилт хөдөлгөөний таамгуудад суурилсан хэтийн тооцооллын аргыг ашиглан тооцсон.

Ажлын даалгаврын дагуу тооцооллыг дунд буюу 5 жилийн хугацаанд, урт хугацааны тооцооллыг 60 жилээр тооцох тул дунд хугацаанд 2023 оны дуусаж байгаа учир 2023-2028 он хүртэл хугацааг, урт хугацаанд 2023-2082 онуудыг авч үзэв.

ТООН МЭДЭЭЛЭЛ БОЛОН ХОЛБОГДОХ ТААМГУУД

Доорх тооцооллын суурь мэдээллийг Үндэсний статистикийн хорооны (ҮСХ) мэдээллийн сангаас хүйсээр болон насны бүлгээр авч холбогдох таамгуудыг дэвшүүлэн цаашид 5 жилийн мөчлөгтэйгөөр 60 жилийн хугацаанд таамаглан тооцсон. Тооцооллын голлох үзүүлэлтүүд болон тэдгээртэй холбоотой хийгдсэн таамгуудыг холбогдох хэсгүүдэд тусгасан болно.


Динамик загварын хувьд тооцооллыг хүн амын болон эдийн засгийн өсөлтийн 3 түвшнээр харуулах шаардлагатай байсан бөгөөд холбогдох сонголтуудыг “Таамгууд” хуудаст оруулсан.

Бүтээгдэхүүн 1 хувьд орлогыг зөвхөн нийгмийн даатгалын шимтгэл, татварын буцаалт, хөнгөлөлт болон халамжийн төлбөрүүдээс бүрдэнэ гэж тооцсон болно. Сангийн хөрөнгө оруулалтын орлогын тооцоо ажлын даалгаврын дагуу Бүтээгдэхүүн 2-т хийж, хөрөнгө оруулах хуримтлал нь Бүтээгдэхүүн 3-т тооцогдсон зарцуулалт болон дараа дараагийн жилүүдийн орлогын хэмжээнээс хамааралтай байх юм.

МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ

Хүн амын хэтийн тооцоо нь нийт хүн амын нас баралт, төрөлт болон шилжилт хөдөлгөөний динамик болон эдгээрийн хэтийн талаар хийсэн таамгуудад мэдрэг тул эдгээр хүчин зүйлүүдийн өнгөрсөн 10 жилийн тоон мэдээллийг шинжлэн таамаг гарган ирээдүйн хэмжээг тооцсон.

Зураглал 1 - МУ хүн ам насны бүлгээр, 2022 - ҮСХ



ТӨРӨЛТ

ҮСХ-ны өнгөрсөн 10 жилийн төрөлтийн коэффициентын мэдээллийг судлахад тус үзүүлэлт нь жил ирэх тусам буурч байгаа төлөвтэй байна. Хэдийн ерөнхий байдлаар буурч байгаа ч энэхүү 10 жилийн хугацаанд 3 жил дараалан бага хэмжээгээр буурч, дараагийн 2 жил бага зэрэг өсөлтийг үзүүлж байгаа дүр төрх ажиглагдаж байгаа юм.

Хүснэгт 1 - Төрөлтийн коэффициент 2013-2022


Насны бүлэг	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
15-19	28.8	26.7	29.9	32.7	30.6	31.2	30.7	26.9	23.8	21.9
20-24	160.1	152.7	155.3	156.4	145.7	149.8	147.6	141	127	129.2
25-29	176.3	173.9	168.7	164.2	153.4	162.1	166.7	165	159	157.7
30-34	125.8	142.8	137.1	130.3	125.6	131.3	134.7	135.2	129.9	125.6
35-39	83.3	92.1	87.1	83.3	80.4	85.1	91.9	92.2	90.3	83
40-44	23.2	31.3	23.5	21.8	21	23.3	24.3	25.4	25.7	23.8
45-49	3.6	4.5	1.3	1.2	1.3	1.2	1.2	1.5	1.3	1.6
Өөрчлөлт		4%	-1%	-3%	-6%	4%	1%	-2%	-6%	-9%

Төрөлтийн коэффициентийг хэтийн тооцоололд ашиглахдаа тус хэлбэлзлийг харгалзан 2023-2027, 2028-2032, 2033-2052, 2053-2082 онуудад тус тус төрөлтийн коэффициентын өсөлт / бууралтын таамаг гаргаж тус онуудад ашигласан. Ажлын даалгаврын хүрээнд хүн амын өсөлтийг “өндөр”, “дунд”, “бага” гэсэн 3 түвшинд тооцох байсан тул тус бүрд дараахыг таамагласан:

Хүснэгт 2 - Төрөлтийн коэффициентын таамгууд


Хувилбар	2023-2027	2028-2032	2033-2052	2053-2082
Өндөр	3.0%	-1.0%	4.0%	0.0%
Дундаж	-5.0%	-6.0%	2.0%	-9.0%
Бага	-10.0%	-7.6%	1.0%	-11.0%

Зураглал 2 - Төрөлт



Хүйсийн харьцаа: Төрсөн эрэгтэй, эмэгтэй хүүхдийн хүйсийн харьцааг сүүлийн 10 жилийн төрөлтийн статистикийн мэдээллийг үндэслэн дундажлан тооцсон болно. Эрэгтэй хүүхдийн эзлэх хувь 51.4%, харин эмэгтэй хүүхдийн эзлэх хувь нь 48.6% бөгөөд энэхүү харьцаа нь хэтийн тооцоонд тогтмол байдлаар ашиглагдсан болно.

Хүснэгт 3 Төрөлтийн тоо, хүйсийн харьцаа 2013-2022




НАС БАРАЛТ

Хүн амын тооцоололд нас баралтын түвшнийг ашиглан тухайн бүлгийн амьд үлдэх харьцааг гаргадаг. Энэхүү үзүүлэлтийг мөн өнгөрсөн 10 жилийн ҮСХ-ны хүн амын нас баралтын мэдээллээс тооцож гаргасан бөгөөд төрөлт хэсэгт ашигласан цаг хугацааны бүлэг бүрд тус үзүүлэлтийг таамгийн дагуу өсгөж, бууруулан тооцоололд доорх байдлаар оруулсан.

Хүснэгт 4 - Нас баралтын түвшний хувилбарууд

Хувилбар	2023-2027	2028-2032	2033-2052	2053-2082
Өндөр	-9.0%	-10.0%	-11.0%	-12.0%
Дундаж	1.0%	-2.0%	-4.0%	-6.0%
Бага	5.0%	3.0%	2.0%	1.0%

Зураглал 3 – Нас баралтын түвшний хувилбарууд



Доорх 4 цаг хугацаанд нас баралтын түвшин буурч байгаа бөгөөд буурч буй хувийг өнгөрсөн 5 жилийн нас баралтын түвшний өөрчлөлтийг харгалзан гаргасан бөгөөд Ковид-19 цар тахлаас үүссэн нас баралтын түвшнийг хасаж тооцсон болно. Дэлхий нийтэд нас баралтын түвшин багасаж, насжилт нэмэгдэж байгаа чиглэл Монгол улсад ч ажиглагдаж байгаа нь насжилтын тоон мэдээллээс харагдаж байгаа тул 2053-2082 онуудад ашиглах нас баралтын түвшнийг нэлээд өөдрөг дүнгээр тооцсон.

ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

ҮСХ-оос гаргасан “Хүн амын шинэчилсэн хэтийн тооцоо 2020-2050 он” тайлангаас авсан мэдээллээр 2020 оны тооллогоор Монгол Улсын харьяат хүн амын 3.7 хувь гадаадад оршин сууж байсан бөгөөд гадаадад суугаа хүн амын тоо хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоос 14.2 хувиар өссөн гэсэн мэдээллээс дүгнэхэд жил бүр дунджаар 1,520 орчим буюу 5 жилд 7,600 иргэн гадаад улсад шилжин амьдардаг байхаар байна. Энэхүү үзүүлэлтийг 10% өсгөж, нийт 2022 хүн амын тоотой харьцуулж, ирээдүйд шилжих иргэдийн тоог гаргасан. Тус тайлангаар гол төлөв ажиллах хүчний насны иргэд гадаадад шилжин амьдарч байгаа талаар дурдсан байсан тул 15-49 насны бүлэгт хуваарилан тооцсон.

Хүснэгт 3 Төрөлтийн тоо, хүйсийн харьцаа 2013-2022

	2020	2010	5 жилд шилжих иргэдийн тоо
Иргэдийн тоо	122,301	107,094	7,603.65

Шилжиж явсан иргэдийн 71% нь эрэгтэй, 29% нь эмэгтэй гэсэн харьцаа 2023 оны хилээр гарсан иргэдийн хүйсийн мэдээлэл дээр үндэслэн тооцов.

ХҮН АМЫН ТООЦООНЫ ҮР ДҮН

Хүн амын хэтийн тооцоолол нь 5 жилийн мөчлөгтэйгөөр тооцоологдсон бөгөөд 2022 оны суурь мэдээллийг үндэслэн 2082 он хүртэлх цаг хугацааг хамруулсан. Хэтийн тооцооллын үр дүнг ҮСХ-ны “Хүн амын хэтийн шинэчилсэн тооцоолол 2020-2050” тайлангийн үр дүнтэй харьцуулсан хүснэгтийг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 6 - Хүн амын хэтийн тооцоолол


Мянган хүн	2027	2032	2037	2042	2047	2052	2057	2062	2067	2072	2077	2082
Нийт ХА төсөөлөл	3,621	3,838	4,001	4,184	4,378	4,559	4,734	4,834	4,786	4,907	5,043	5,146
Статистикийн газрын тооцоолол	3,624	3,865	4,143	4,467	4,808							

Дунд хугацаа буюу 5 жилийн үр дүнг харуулахын тулд 2023-2027 онуудыг жилээр задалж, мөн 2028 оны үр дүнг хамруулсан болно. Үүнд 5 жилийн нэг жилийн өсөлтийг жигд гэж тооцон 20%-аар тус тус өгсөж гаргасан.

Хүснэгт 7 - Хүн амын тооцоолол - 2023-2028

Мянган хүн	2022	2023	2024	2025	2026	2027	2028
Нийт ХА төсөөлөл	3,466	3,515	3,556	3,596	3,621	3,632	3,466

Зураглал 4 - Хүн амын төсөөлөл



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭ

АЖИЛЛАХ ХҮЧ

Нийгмийн даатгалын шимтгэл төлдөг иргэдийн тоог тооцоолоход 2018-2022 онуудын ҮСХ-ны мэдээллийн сангаас ажиллах хүчний оролцооны түвшин болон хөдөлмөр эрхлэлтийн түвшний үзүүлэлтүүдийг авч үзсэн.


Хөдөлмөр эрхлэлтийн түвшин нь хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувийг ажиллагчид эзэлж байгааг харуулдаг үзүүлэлт тул тус үзүүлэлтээр нийт хүн амын ажилчид буюу нийгмийн даатгал төлдөг иргэдийн тоог насны бүлэг болон хүйсээр гаргах боломжтой.

Хүснэгт 8 - Хөдөлмөр эрхлэлтийн түвшний таамаг

Насны бүлэг	2018, %		2019, %		2020, %		2021, %		2022, %		ХЭТ 2023-2031		ХЭТ 2032-2052		ХЭТ 2053-2082	
	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
15-19	12.1	3.8	11.1	4.9	14.7	5.0	11.7	3.9	10.4	5.2	10.4	3.8	12.0	4.6	12.6	5.0
20-24	50.9	34.3	49.9	36.2	50.5	37.4	47.4	28.4	55.6	37.1	47.4	28.4	50.9	34.7	53.4	38.1
25-29	77.9	54.7	78.5	56.9	78.4	62.6	76.8	55.3	78.3	64.4	76.8	54.7	78.0	58.8	81.9	64.7
30-34	86.6	65.0	82.2	64.8	83.3	62.8	87.0	60.0	84.9	60.9	82.2	60.0	84.8	62.7	89.0	69.0
35-39	86.3	71.6	78.9	70.7	83.3	69.6	83.6	69.5	84.0	66.8	78.9	66.8	83.2	69.6	87.4	76.6
40-44	83.8	75.7	82.3	75.3	81.5	68.5	75.4	72.3	82.0	72.6	75.4	68.5	81.0	72.9	85.1	80.2
45-49	82.3	77.6	77.9	75.0	76.4	74.5	73.9	70.1	81.2	74.9	73.9	70.1	78.3	74.4	82.3	81.9
50-54	73.1	63.8	70.7	66.0	69.5	66.4	70.5	66.0	72.2	70.1	69.5	63.8	71.2	66.5	74.8	73.1
55-59	59.8	33.8	62.0	33.9	58.0	36.2	56.9	32.2	58.8	32.5	56.9	32.2	59.1	33.7	62.1	37.1
60-64	26.0	17.7	30.2	21.1	30.0	17.1	23.2	19.6	28.0	24.1	23.2	17.1	27.5	19.9	28.9	21.9
65-69	18.6	13.3	22.1	10.7	19.1	12.7	21.4	10.2	18.4	8.6	18.4	8.6	19.9	11.1	20.9	12.2
70+	11.4	5.2	9.7	5.9	10.5	5.0	6.7	5.0	6.3	3.6	6.3	3.6	8.9	4.9	9.4	5.4

ХЭТ 2023-2031 онуудад өмнөх 5 жилийн хамгийн бага ХЭТ-ийн үзүүлэлт, 2032-2052 онуудад өнгөрсөн 5 жилийн ХЭТ-ийн дундаж, харин 2053-2082 онуудад өмнөх мөчлөгийн ХЭТ-ийн дүнг 5% өсгөж ашигласан болно.

Зураглал 5 - Хүн ам зүйн ачаалал




Төрийн тусгай албан хаагч: ҮСХ-ны мэдээллийн санд нийт төрийн тусгай албан хаагчийн тоог хүйсээр гаргасан боловч насны ангиллаар гаргаагүй байсан. Тиймээс нийт төрийн тусгай албан хаагчдын тоог нийт ажлын хүчинд харьцуулан хувь хэмжээг гаргаж, цаашид тус бүлгийн иргэдийн тоог нийт тооцох ажлын хүчний тооноос тус хувиар тооцов.

Ажиллах хүчийг ажиллах хүчний оролцооны түвшний үзүүлэлтийг хүн амын тоод үржүүлэн гаргав. Тус үзүүлэлтийн мөн 3 цаг үеийн мөчлөгөөр тус тус таамаг гаргаж тооцов.

Нийт нийгмийн даатгал төлдөг ажилчдын тооноос төрийн тусгай албан хаагчдын тоог хасаж тооцов.

Сүүлийн 3 жилийн нийгмийн даатгалын шимтгэлийн албан журмаар болон сайн дураар төлсөн иргэдийн тоог харьцуулан хоорондын харьцааг харгалзаж, дундаж үзүүлэлтээр цааш хэтийн тооцоонд нийт нийгмийн даатгалын шимтгэл төлдөг иргэдийн тоог албан журмаар болон сайн дураар төлөгчөөр хуваарилав.

Зураглал 6 - Эдийн засгийн үзүүлэлтүүдийн бодит дүн болон таамаг



Хүснэгт 9 - Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэдийн тоо

Үзүүлэлт	2020		2021		2022		Тооцоололд ашигласан харьцаа
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	
Нийгмийн даатгалд даатгуулагчид	1,013,190		1,019,114		1,069,628		
Албан журмаар даатгуулагчид	826,064	81.53%	862,071	84.59%	913,090	85.37%	85.37%
Сайн дураар даатгуулагчид	187,126	22.65%	157,043	15.41%	156,538	14.63%	14.63%

ИНФЛЯЦ, ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ БОЛОН ЦАЛИНГИЙН ӨСӨЛТ, ДУНДАЖ ЦАЛИН

Дундаж цалингийн өсөлтийн хэмжээг тооцоолоход ҮСХ-ны мэдээллийн сангаас нийт ажилтнуудын тоо, ДНБ-ний хэмжээ, инфляцын түвшин зэргийг авч тооцоолсон бөгөөд ирээдүйн өсөлтийн хэмжээг тооцоолохдоо Олон Улсын Валютын Сан-гийн төсөөллийг ашигласан болно.

Гадаад болон дотоодын судалгааны ажлуудаас үзэхэд иргэдийн дундаж цалингийн хэмжээнд тухайн улсын инфляц, тухайн ажиллагчийн туршлага, бүтээмж зэрэг үзүүлэлтүүд гол нөлөөг үзүүлдэг гэж гарсан байдаг бөгөөд тооцооллын цар хүрээг авч үзэн макро факторууд болох инфляц болон бүтээмжийг голчлон авсан болно. Ингэхдээ бүтээмж нь нэг ажиллагчид ногдох ДНБ байх бөгөөд үүнийг ДНБ-ний суурь дүнгээр орлуулан авсан болно.

Хүснэгт 10 - ДНБ-ийн өсөлт, инфляцын таамаг

	Бодит байдал					Ирээдүйн төсөөлөл/тооцоолол						Тогтм ол өсөлт
	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	
ДНБ-ийн өсөлт	7.60%	5.50%	4.40%	1.62%	4.95%	5.50%	4.50%	3.50%	3.50%	3.50%	4.00%	4.00%
Инфляц	8.10%	5.20%	2.30%	13.80%	13.20%	12.30%	12.20%	12.00%	10.50%	8.90%	7.00%	7.00%
Дундаж цалингийн өөрчлөлт	6.18%	12.10%	8.57%	4.82%	17.54%	12.66%	8.56%	8.00%	6.80%	5.52%	4.20%	5.88%
Дундаж цалингийн хэмжээ /сая төгрөг/	1.00	1.12	1.22	1.28	1.50	1.69	1.84	1.99	2.12	2.24	2.33	1.00

Олон Улсын Валютын Сан-гийн төсөөлсөн МУ-ын 2028 оны макро үзүүлэлтийг ирээдүйн дундаж төсөөллөөр авч үзэхэд ирэх 60 жилийн хугацаанд МУ-ын НДШ албан журмаар төлдөг иргэдийн дундаж цалингийн хэмжээ 5.88%-аар өсөх хандлагатай байна.

САЙН ДУРААР ДААТГУУЛАГЧДЫН ДУНДАЖ ШИМТГЭЛ

Сайн дураар даатгуулагчдын шимтгэлийн хэмжээг тооцоход ҮСХ-оос тэтгэврийн даатгалын сангийн орлого, НДС-д даатгуулагчдын тоо үзүүлэлтүүдийг авч үзсэн болно. Дээрх тооцоолоос сайн дураар даатгуулагчдын хувьд НДШ-ийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр төлөх хандлагатай байдаг бөгөөд дунджаар жилд 5 сарын

хугацаанд НДШ төлдөг байна.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өөрчлөлт УИХ-ын шийдвэрээс хамааран өөрчлөгддөг тул тооцооллын хүрээнд дундаж цалингийн өсөлттэй хамааруулан өсгөн авч үзлээ.

САНГИЙН БУСАД ОРЛОГО

ХАЛАМЖ БОЛОН ТЭТГЭМЖИЙН ОРЛОГО

ХНС-д орох халамж болон тэтгэмжийн орлогыг хүүхдийн мөнгө болон жирэмсэн эхийн тэтгэмжээр тооцсон болно. Ингэхдээ нийт хүн амын тооцоолол, түүнээс нийт хүүхэд болон жирэмсэн эхийн тоог гарган авч тэдгээрийн нэг НДШ төлөгчид хамаарах тоо хэмжээг гарган авснаар тооцсон.

Зураглал 7 - Тэтгэмжийн орлогын таамаг



Иргэдийн НӨАТ-ын буцаалтын хэмжээнээс ХНС-д байршуулах хэмжээг эдийн засгийн нөхцөл байдлаас хамааран халамж, тэтгэмжийн байршуулах хэмжээтэй адилаар буюу 30%-аар тооцоолон авсан болно. Гэсэн хэдий ч уг хэмжээ нь тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдал, иргэдийн хандлага зэргээс хамааран өөрчлөгдөх бүрэн боломжтой юм. Энэхүү үзүүлэлтийг тооцооллын загварт хувьсах хэлбэрээр оруулсан бөгөөд өөрчлөн үр дүнг харьцуулах боломжтой.

ТАТВАРЫН ОРЛОГО

ТАТВАРЫН БУЦААН ОЛГОЛТ, ХӨНГӨЛӨЛТ


ҮСХ-ны мэдээллийн сангийн өрхийн дундаж орлого, зарлага, өрхийн дундаж зарлагын задаргаа зэрэг үзүүлэлтүүдийн тусламжтайгаар НӨАТ-ын буцаан олголтын тооцоолсон болно.

Ингэхдээ өрхийн зарлагын хүнсний болон хүнсний бус бараа үйлчилгээний зардлын дунджаар 70% орчим нь НӨАТ-тай зардал байна гэж үзсэн бөгөөд уг дүнг 2020 оны НӨАТ-ын буцаан олголтын дундаж статистик үзүүлэлтэд тулгуурлан гаргасан болно.

Цаашлаад өрхийн орлогод эзлэх цалингийн хэмжээгээр өрхийн орлогын ирээдүйн төсөөллийг гаргасан бөгөөд үүнд сүүлийн 10 жилийн өрхийн орлого, зарлагын харьцаа болох 98%-ийг ашигласан бөгөөд үүнд үндэслэн өрхийн зарлага мөн түүнд хамаарах НӨАТ-ын буцаан олголтын хэмжээг гарган авсан болно.

Мөн түүнчлэн ХХОАТ-ын 23.3 болон 23.4 дүгээр заалтуудад заасны дагуу зээлийн хөрөнгөөр амьдрах суух зориулалтаар анх удаа орон сууц авсан, мөн түүнчлэн иргэний хүүхэд гадаад, дотоодын их дээд сургуульд суралцсан зэрэг тохиолдлуудад татварын хөнгөлөлт үзүүлдэг бөгөөд 2022 онд нийт ₮63 тэрбумын буцаалтыг олгосон байна. Цаашид уг хөнгөлөлтийг тооцоолохдоо нийт хүн ам болон тэдний орлогын өөрчлөлтөд үндэслэн гаргасан болно. Ингэснээр иргэдийн ХНС-д байршуулах боломжтой татварын хөнгөлөлтийн хэмжээг гаргаж байна.

Зураглал 8 - НӨАТ буцаан олголт



Хүснэгт 11 - НӨАТ-н буцаан олголтын таамаг

	Бодит байдал					Ирээдүйн төсөөлөл/тооцоолол						
	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	
Өрхийн дундаж орлого /сая төгрөг/	1.20	1.38	1.42	1.64	1.85	2.13	2.39	2.65	2.90	3.13	3.31	
Өрхийн орлого – цалин /сая төгрөг/	0.60	0.69	0.71	0.71	0.94	1.17	1.31	1.46	1.60	1.72	1.82	
Цалингийн эзлэх хувь	49.85%	49.88%	50.04%	42.91%	50.75%	55.00%	55.00%	55.00%	55.00%	55.00%	55.00%	
Өрхийн орлого зарлагын харьцаа	96.87%	97.07%	93.76%	109.59%	100.94%	98.00%	98.00%	98.00%	98.00%	98.00%	98.00%	
Өрхийн дундаж зарлага /сая төгрөг/	1.24	1.42	1.52	1.50	1.83	2.09	2.34	2.60	2.85	3.07	3.25	
Мөнгөн худалдан авалтын зардал /сая төгрөг/	1.12	1.27	1.38	1.35	1.66	1.88	2.10	2.34	2.56	2.76	2.92	
НӨАТ олгож болохуйц орлогын хувь	89.90%	89.99%	90.59%	89.93%	90.81%	90.00%	90.00%	90.00%	90.00%	90.00%	90.00%	
НӨАТ-ын буцаан олголтын орлого жил /сая төгрөг/	0.16	0.18	0.19	0.19	0.22	0.25	0.27	0.31	0.33	0.36	0.38	

ҮР ДҮН – БҮТЭЭГДЭХҮҮН 1

Энэхүү тооцоолол нь 2022 оны тоон мэдээлэл, хүн амын болон эдийн засгийн олон үзүүлэлт болон тэдгээрийн таамагт суурилсан тул ирээдүйн төсөөлөл бүхий тооцоолол тул бодит байдлаас зөрөх боломжтой.


Үрдүнг 3 түвшинд гаргасан: ХНС-ийн түвшинд, албан журмын даатгуулагчийн түвшинд

болон өрхийн хэмжээнд эдийн засгийн болон хүн амын таамаглалыг “Дундаж” утгаар авч үзлээ. Хөрөнгө оруулалтын өгөөж болон зарцуулалтын тооцоолол ороогүй болно. Өрхийг 4 ам бүлтэй, 2 албан журмын даатгуулагч болон 2 хүүхдээс бүрдэнэ гэж авч үзэв.

Үр дүнг Хавсралт 1-ээс харна уу.

	Үзүүлэлтээр	Дүнгээр	Төрөлтийн хүйсийн харьцаа	Жиших утга 10 жилийн дундаж
Эдийн засгийн өсөлт	Дундаж	4.0%	% эр төрөлт	51.4%
Инфляцын түвшин	Дундаж	7.0%	% эм төрөлт	48.6%
Хүн амын өсөлт	Дундаж	0.7%	Нэг өрхийн хүн амын тоо	3.5
			Хүүхдийн мөнгөний хэмжээ /cap/	100,000.00
Халамж, тэтгэмжийн хадгалалтын түвшин	30.0%			
Цалинтай эх - дундаж тэтгэмж авах хугацаа	11			
Цалинтай эх - сарын төлбөр	50,000.00			
НӨАТ-ын хадгалалтын түвшин	30.0%			

Зураглал 9 - ХНС орлогын хэмжээ /хөрөнгө оруулалт болон зарцуулалт ороогүй/



II. ХУРИМТЛАЛЫН НЭГДСЭН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДУНД БОЛОН УРТ ХУГАЦААНЫ ТААМАГЛАЛ


ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

ХНС-ийн хуулийн төсөлд сангийн хөрөнгийн 85 ба түүнээс доошгүй хувийг хөрөнгө оруулалтад, 15 хүртэл хувийг сангийн гишүүнд зарцуулах зорилгоор хуримтлалын сангийн нөөц санд байршуулна гэж заасан. Ингэснээр хөрөнгө оруулалтын хөрөнгийг урт хугацааны өгөөж өндөртэй хөрөнгө оруулалтуудад оруулах, харин нөөц сангийн хөрөнгийг хөрвөх чадвар өндөртэй богино хугацааны өгөөж багатай хөрөнгө оруулалтад оруулах зохицуулалт хийгдэж байна. Мөн түүнчлэн ХНС-ийн хөрөнгийн удирдлагын жилийн өгөөж Монголбанкны бодлогын хүүний дунджаас доошгүй байна гэж заасан нь хөрөнгө оруулалтын доод өгөөжийг тооцоолох суурь өгөөж болж өглөө.

БОДЛОГЫН ХҮҮНИЙ ТААМАГЛАЛ

Монголбанкны хувьд сүүлийн жилүүдэд бодлогын хүүг инфляцыг онилсон байдалтайгаар тогтоож байгаа билээ. Хөгжингүй болон өндөр хөгжилтэй хэд хэдэн улс орнуудын төв банкууд мөн инфляцыг онилох мөнгөний бодлого барьдаг нь Монголбанк урт хугацаандаа мөнгөний бодлогоо хэвээр хадгалах нөхцөл байгааг харуулж байна. Иймд бодлогын хүүний ирээдүйн төсөөллийг хийхдээ Монголбанк одоогийн инфляцыг онилох бодлогоо хэвээр хадгална гэж авч үзлээ.


Зураглал 10 - Бодлогын хүү болон инфляц



Бодлогын хүүгээр инфляцын түвшинг онилсноор урсгал орлого болон зардал зэрэг удирдагдах бөгөөд ингэснээр бодлогын хүү болон төлбөрийн тэнцлийн урсгал дансны дүн хоорондоо эерэг хамааралтай байдаг.

Ингэснээр дээрх хамаарлуудыг авч үзэн ХНС-ийн хөрөнгө оруулалтын суурь өгөөж болох Монголбанкны бодлогын хүүг инфляцын дундаж түвшин, хэрэглээний үнийн индексийн өөрчлөлтийн түвшин, төлбөрийн тэнцлийн урсгал дансны дүнгээс хамааруулан тооцоход дараах үр дүн гарсан.

Зураглал 11 - Бодлогын хүүний таамаглал



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮН – БҮТЭЭГДЭХҮҮН 2

ХНС-ийн хөрөнгө оруулалтын бодлогыг харгалзан авч үзэн хөрөнгө оруулалт болон хуримтлалын сангийн нөөцийн өгөөжийг бодлогын хүүтэй уялдуулан авч үзлээ. Ингэхдээ харилцах хадгаламжийн жигнэсэн дундаж хүү болон ЗГ-ын үнэт цаасны хүү зэргийг харгалзан авч үзсэн болно.

Хуулийн төслийн зөвшөөрөгдөх хөрөнгө оруулалтад заасан аймаг нийслэлийн үнэт цаас, дотоод болон гадаадын бизнес эрхлэгчдийн үнэт цаас, үүсмэл санхүүгийн хөрөнгө зэрэг хөрөнгийн зах зээлийн хэрэгслүүдийн өгөөжийг ирээдүйд тооцоолоход хүндрэлтэй тул эдгээрийг банкны хадгаламж, Монголбанкны үнэт цаас зэргээр төлөөлүүлэн тооцооллоо.

Хүснэгт 12 - Хөрөнгө оруулалтын үр дүн

Он	НДШ-ийн орлого	Нийт орлого	Хуримтлагдсан орлого	Хөрөнгө оруулалтын дараах хуримтлагдсан орлого/зардал тооцоогүй
2024	447,801,685,362	1,020,836,902,044	1,020,836,902,044	1,085,956,336,304
2025	487,320,974,511	1,075,131,005,346	2,095,967,907,390	2,355,226,148,338
2026	524,478,736,126	1,126,552,971,293	3,222,520,878,684	3,765,463,643,109
2027	556,033,570,766	1,168,610,099,594	4,391,130,978,278	5,370,898,958,154
2028	587,335,462,513	1,206,044,147,696	5,597,175,125,974	7,161,584,516,902
...	-	-	-	-
2029-2032	2,911,984,196,120	5,482,153,256,820	11,079,328,382,794	16,280,478,114,815
...	-	-	-	-
2033-2037	5,087,364,477,480	8,503,064,002,371	19,582,392,385,165	33,598,165,967,592
...	-	-	-	-
2038-2042	7,136,264,934,680	10,934,963,219,338	30,517,355,604,503	61,081,087,986,395
...	-	-	-	-
2043-2047	9,854,299,515,263	14,301,710,219,790	44,819,065,824,292	103,804,129,807,928
...	-	-	-	-
2048-2052	13,489,377,074,289	18,836,986,892,729	63,656,052,717,021	166,753,719,111,980
...	-	-	-	-
2053-2057	19,320,254,269,357	26,038,912,044,314	89,694,964,761,335	259,299,944,888,006
...	-	-	-	-
2058-2062	27,262,773,383,722	35,707,207,973,153	125,402,172,734,489	383,035,322,313,478
...	-	-	-	-

Он	НДШ-ийн орлого	Нийт орлого	Хуримтлагдсан орлого	Хөрөнгө оруулалтын дараах хуримтлагдсан орлого/зардал тооцоогүй
2063-2067	37,472,287,972,485	48,027,244,255,295	173,429,416,989,783	547,182,293,789,639
...	-	-	-	-
2068-2072	51,191,600,584,027	64,568,931,776,387	237,998,348,766,170	772,294,075,308,970
...	-	-	-	-
2073-2077	69,494,598,171,756	86,702,846,828,009	324,701,195,594,178	1,078,946,511,853,760
...	-	-	-	-
2078-2082	93,780,340,374,004	116,145,763,228,000	440,846,958,822,179	1,494,928,422,471,700

Хөрөнгө оруулалтын дээрх үр дүн нь хөрөнгө оруулалтын стратеги, макро эдийн засгийн нөхцөл байдал, сангийн удирдлагын шийдвэр зэргээс хамааран бүрэн өөрчлөгдөх боломжтой юм.

III. ХУРИМТЛАЛЫН НЭГДСЭН САНГИЙН ЗАРЛАГЫН ДУНД БОЛОН УРТ ХУГАЦААНЫ ТААМАГЛАЛ

АРГА ЗҮЙ

ХНС-ийн хуулийн төсөл болон ажлын даалгаврын дагуу ХНС-ийн орлого нь зарлагын зориулалтад үндэслэн хоёр дансанд хуваарилагдах зохицуулалттай:

- Тэтгэврийн дансанд даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг 30-аас доошгүй хувийг хуримтлуулна;
- Энгийн дансанд даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн хувийн 70 хүртэл хувь болон төрөөс иргэнд олгох хишиг, орлогын дэмжлэг, ногдол ашгийн орлого, татварын буцаан олголт, нэмэгдсэн өртгийн албан татварын урамшуулал, хүүхдийн мөнгө болон цалинтай ээжийн халамжийн олговор болон иргэний өөрийн хуримтлал орно.

Тооцоололд энгийн дансанд хуримтлагдсан нэмэлт орлогод халамжийн болон тэтгэмжийн олговорууд, НӨАТ-ын буцаан олголтоос гадна орон сууц худалдан авалтын болон сургалтын төлбөрийн татварын буцаан олголтыг авч үзсэн болно. Төрөөс иргэнд олгох хишиг, ногдол ашгийн давтамж болон дүнгийн хувьд ямар нэгэн бодит таамаг гаргахад хүндрэлтэй тул тооцооллоос хасаж үзсэн. Мөн халамж, тэтгэмж, бусад олговорууд нь сайн дурын үндсэн дээр хуримтлалын дансанд хадгалагдах тул иргэдийн зан төлөв, амьжиргааны төрхөөс таамаг үүсгэхэд хуримтлах магадлал тун бага байхаар байна. Тиймээс тооцооллын загварт тэтгэмж, халамж болон татварын хуримтлалд хийгдэх хувьсах хувийг оруулж өгсөн. Тус үзүүлэлтийг 0% болгож огт хуримтлагдахгүй, ямар нэгэн хувь оруулснаар нийт дүнгийн тэдэн хувь нь ХНС-д хуримтлагдана гэж авч үзэх боломжтой.

Тэтгэврийн дансны хуримтлал нь өндөр насны тэтгэвэрт зориулагдах бөгөөд энгийн дансны хуримтлал даатгуулагчийн бусад хэрэгцээнд зарцуулагдах нээлттэй зохицуулалттай байна:

- Орон сууцны анхны худалдан авалтын урьдчилгаа
- Түрээсийн орон сууцны төлбөр
- Боловсрол
- Эрүүл мэнд
- Тэтгэвэр

Эдгээр зарцуулалтын тооцоолол, хийгдсэн судалгааг тус бүр авч үзье.

ИПОТЕКИЙН УРЬДЧИЛГАА


Ипотекийн орон сууцны зээлтэй холбоотой мэдээ, мэдээллийг судлахад ҮСХ-оос тус зээлийн хөтөлбөр эхэлснээс хойш олгогдсон нийт зээлийн тоо болон зээлийн үлдэгдлийн хэмжээ он оноор гарч байсан бөгөөд энэ нь дундаж зээлийн хэмжээ болон жилд санхүүжигдэх зээлийн тоог таамаглахад хангалттай мэдээлэл байх боломжгүй юм. Ирээдүйд олгогдох ипотекийн зээлийн тоо, хэмжээг тооцоход нээлттэй мэдээллийг судлахаас гадна ХНС-ийн зарцуулалтын бүлэгт заасан шаардлагыг

хангасан даатгуулагчийн тоо зэргийг харгалзаж үзэв.

Шаардлагыг хангасан даатгуулагчийн тоо


2006-2023 оны даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтийн судалгаанаас үзэхэд 7 болон түүнээс дээш хугацаанд шимтгэлээ төлсөн даатгуулагч нийт даатгуулагчийн 30% эзэлж байгаа бөгөөд ирээдүйд энэ тоо хэвээр байна гэж үзэн таамагласан даатгуулагчийн тооноос 30% нь "7 ба түүнээс дээш жил шимтгэл төлсөн" шалгуурыг хангасан гэж үзлээ.

Зураглал 12 - Даатгуулагчийн тоо - таамаг




Орон сууцны үнийн өсөлтийг доорх статистикийн мэдээлэлд үндэслэн 9% гэж үзсэн бөгөөд ХНС-ийн хөрөнгөөс ипотекийн зээлийн санхүүжилтээр худалдан авах орон сууцны урьдчилгаа төлбөр олгох журмын 4.2-т зааснаас 65 сая төгрөгийн тааз тогтоосон байна. Үүсэж буй хуримтлалын хэмжээ болон орон сууцны үнийн өсөлтөөс хамаарч даатгуулагч ипотекийн урьдчилгааны хэрэгцээгээ хангах боломжгүй нь тооцоогоор гарч байна.

Зураглал 13 - Орон сууцны үнийн мэдээ 2023 - ҮСХ



Ипотекийн зээлийн олголтын статистик


Зураглал 14 - Ипотекийн зээлд хамрагдсан орон сууц талбайн хэмжээгээр



Дээрх хуваарилалтаас зээлд хамрагдах дундаж орон сууцны талбай жигнэсэн дундаж аргаар тооцож 55 м.кв гэж үзлээ.

ҮСХ-ны мэдээллээр тус орон сууцны хөтөлбөр эхэлснээс хойш 2023 оны 12-р сарын байдлаар нийт 114.8 мянган иргэн хамрагдаж, нийт зээлийн үлдэгдэл 7,643.8 тэрбум төгрөг байна¹.

Зураглал 15 - Ипотекийн зээлд хамрагдсан иргэдийн тоо - ҮСХ



Сүүлийн 5 жилийн байдлаар жил бүр олгогдсон зээлийн тоог үзэхэд, зээлийн олголт 2020-2021 онуудад оргилдоо хүрч байсан бөгөөд 2022 оноос буурж эхэлсэн бөгөөд үүний тайлбар нь ипотекийн зээлийн санхүүжилт нь өмнө нь олгогдсон зээлүүдийн эргэн төлөлтөөс санхүүждэг бөгөөд Ковид-19-тэй холбоотойгоор зээлийн эргэн төлөлт хойшлогдсон нь зээл олголтод шууд сөргөөр нөлөөлсөн байна. Сангийн сайд болон Монгол Банкны мэдэгдлээс одоогоор нийт идэвхтэй зээлийн эргэн төлөлт 360 тэрбум төгрөг байх бөгөөд шинээр олгогдох зээлийн хэмжээ энэхүү дүнгээр хязгаардаг юм. Ипотекийн зээлийн зохицуулалтаар зээлийн 60%-ийг Монголбанк санхүүжүүлж, харин 40%-ийг арилжааны банкнууд санхүүжилдэг тул 2024 онд нийт

ипотекийн зээлд олгогдох санхүүжилтийг 600 тэрбум төгрөг гэж авч үзээд цааш жил 6%-аар өсгөөд тооцсон.

Орон сууцны үнийн өсөлт дунджаар 9% байгаа бөгөөд үүгээр цааш тооцоололд иргэний хуримтлал байрны урьдчилгаанд хүрэх нөхцөл байдал бага байгааг тооцоолол харуулж байна.

Ипотекийн зээлд хамрагдсан иргэд, тэдгээрт тавьж буй шаардлагаар ихэвчлэн аж ахуйн нэгжид ажил хийж нийгмийн даатгалын шимтгэл төлдөг иргэд хамрагддаг тул дээрх санхүүжилтэд даатгуулагч нар 100% хамрагдана гэж үзлээ.

ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦ

ХНС-гийн түрээсийн орон сууцны зарцуулалтыг тооцоолохдоо “Төрийн орон сууцны корпораци” дахь мэдээллийг үндсэн сууриа болгон ашигласан бөгөөд шаардлагатай нэмэлт мэдээллүүдийг ҮСХ-ноос авч үзлээ.

ТОСК дахь хамгийн сүүлчийн мэдээгээр нийт түрээслээд өмчлөх боломжтой 1'512 орон сууц байгаагаас 850 орон сууц түрээслэгчтэй байна. Мөн одоогоор хэрэгжиж буй нийт 12'190 айлын орон сууцны 3 төсөл байгаа бөгөөд эдгээр төслүүд нь 2027, 2028 онуудад дуусахаар төлөвлөгдсөн байгаа боловч бодит байдал, төслийн одоогийн хэрэгжилтийн явц зэргийг харгалзан үзэж тооцоололд зарим төслийн дуусах хугацаа тодорхой байдлаар хойшлуулж авч үзсэн болно.

Шинээр хэрэгжүүлж буй Солонго 1 болон 2, Залуус 1, Эко яармаг 1 төслүүдийн байрны үнийн тооцоолол болон дундаж мк.в-ын тооцооллыг хийхдээ одоогийн ТОСК-ийн сан дахь байрнуудад суурилан гаргасан болно. Ингэхдээ байрны үнэд нөлөөлдөг томоохон хүчин зүйлүүдийн нэг нь байршил буюу газрын үнэ байдагтай холбоотойгоор Буянт-Ухаа 2 цогцолборыг жишиг болгон авлаа. ҮСХ-ны мэдээллээс үзэхэд сүүлийн жилүүдэд байрны үнэ дунджаар 9%-р нэмэгдсэн байгаа бөгөөд Буянт-Ухаа 2 цогцолборын ашиглалтад орсон хугацааг харгалзан авч үзсэнээр шинээр ашиглалтад орох байрнуудын дундаж үнэ ₮ 2 сая-аас эхлэхээр тооцоолсон болно. Харин дундаж мк.в-ын хувьд ТОСК-ийн санд буй орон сууцуудын дундаж буюу 51 мк.в авж үзсэн болно. Эдгээрийн үр дүнд түрээслээд өмчлөх байрны төлбөрийг тооцооллыг гаргах боломжтой болж байгаа юм.

ТОСК үйлчилгээний нөхцөлд иргэн нь түрээсийн байрны төлбөрийг нийт үнийн дүнгийн 30% буюу ипотекийн урьдчилгаа төлбөрийг 5 жилийн хугацаанд хуваан тэнцүү төлөх, эсхүл нийт үнийн дүнгийн 100%-ийг мөн 5 жилийн хугацаанд тэнцүү төлж орон сууцыг өөрийн эзэмшилдээ авах юм. Мөн уг төлбөр дээр үйлчилгээний шимтгэл болох 26.5%-ийн нэмэгдэл төлбөрийг төлдөг нь шинэ байрны мк.в-ны үнийг ₮ 2.6 сая орчимд авчирч байгаа юм.

Хүснэгт 13 - Түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамрагдах таамаг

Он	Нийт үнэ	Жилийн түрээс Бүрэн өмчлөх	Жилийн түрээс Ипотекийн урьдчилгаа	Өрхийн энгийн дансны хуримтлал
2024	70,329,653	17,793,402	5,338,021	772,827
2025	90,775,974	22,966,322	6,889,896	1,652,474
2026	103,435,644	26,169,218	7,850,765	2,611,120
2027	115,513,624	29,224,947	8,767,484	3,656,481
2028	115,513,624	29,224,947	8,767,484	4,860,100
2029	115,513,624	29,224,947	8,767,484	6,119,368
2030	115,513,624	29,224,947	8,767,484	7,471,925
2031	115,513,624	29,224,947	8,767,484	8,915,453
2032	143,950,992	36,419,601	10,925,880	10,989,694
2033	143,950,992	36,419,601	10,925,880	13,320,962
2034	143,950,992	36,419,601	10,925,880	15,878,535
2035	143,950,992	36,419,601	10,925,880	18,681,361
2036	143,950,992	36,419,601	10,925,880	21,749,777
2037	179,389,126	45,385,449	13,615,635	25,105,607
2038	179,389,126	45,385,449	13,615,635	28,753,720
2039	179,389,126	45,385,449	13,615,635	32,730,987
2040	179,389,126	45,385,449	13,615,635	37,936,793
2041	179,389,126	45,385,449	13,615,635	43,632,301
2042	223,551,489	56,558,527	16,967,558	49,855,976
2043	223,551,489	56,558,527	16,967,558	56,634,838

Дээрх тооцоолоос үндэслэн дундаж өрхийн хуримтлалын дансны зарцуулах боломжтой хэмжээг жилийн төлбөртэй харьцуулахад 2031 он гэхэд ипотекийн урьдчилгааны нэг жилийн төлбөрийг хийх боломж үүсэх бол 2043 он бүрэн эзэмших хэлбэрийн нэг жилийн төлбөрийг төлөх боломж үүсэхээр байна. Үүнээс дүгнэж хэлэхэд түрээсийн орон сууцны төлбөрийг ХНС-гийн данснаас гарган төлөх нь хугацаа шаардах ажил болохоор байна.

БОЛОВСРОЛ

Хуримтлалын нэгдсэн сангийн боловсролтой холбоотой зарцуулалтын тооцооллыг хийхдээ сургуулийн өмнөх боловсрол, бага дунд боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол зэргийн сургалтын төлбөртэй холбоотой баттай эх сурвалжийн мэдээллийн хомс байдал, төлбөрийн хэлбэлзэл, зохицуулалт зэргийг харгалзан үзсэнээр зөвхөн дээд боловсролын төлбөрийн мэдээлэлд үндэслэн тооцооллыг гаргалаа. Ингэхдээ их дээд сургуулийн бакалаврын сургалтын жилийн төлбөрийн тооцооллыг гаргасан бөгөөд ҮСХороо болон БШУЯамны гаргасан статистик мэдээлэлд үндэслэв.

БШУЯамны статистик мэдээллээс үзэхэд сүүлийн жилүүдэд бакалаврын зэргээр суралцаж буй оюутнуудын жилд судалж буй дундаж кредитийн тоо 29 байгаа бөгөөд энэ нь Ковид 19-ын цар тахалтай холбоотой буурсан үзүүлэлт байгаа юм. Их дээд сургуулиудын хөтөлбөрөөс авч үзэхэд бакалаврын зэргээр суралцаж буй оюутан жилд дунджаар 30 кредит судлах шаардлагатай байдаг тул кредитийн хэмжээг 30 гэж тооцон авлаа.

Их дээд сургуулийн бакалаврын зэргийг сонгон судалж буй оюутнуудын дундаж төлбөрийн хэмжээг улсын өрхийн дундаж орлоготой харьцуулан үзэхэд жилийн нийт орлогын 11-13%-ийг эзэлсэн үзүүлэлттэй байгаа бөгөөд уг харьцаа жил бүр буурах хандлагатай байсан болно. Иймд цаашдын бакалаврын зэргийн төлбөрийн тооцооллыг өрхийн жилийн дундаж орлоготой харьцуулан гаргалаа. Мөн түүнчлэн МУ-ын 19-22 насны иргэдийн тоог бакалаврын оюутны тоонд харьцуулан авч үзэхэд 61% орчим хувьтай тэнцүү байгаа тул уг үзүүлэлтийг цаашид хадгалагдана гэж авч үзлээ.

Хүснэгт 14 - Боловсролын зардал болон хамрагдах таамаг

Он	Дундаж төлбөр	Семестрийн төлбөр	Өрхийн энгийн дансны үлдэгдэл
2024	3,336,586	1,668,293	772,827
2025	3,542,860	1,771,430	1,652,474
2026	3,720,087	1,860,043	2,611,120
2027	3,859,364	1,929,682	3,656,481
2028	3,998,391	1,999,196	4,860,100
2029	4,162,240	2,081,120	6,119,368
2030	4,332,802	2,166,401	7,471,925
2031	4,510,354	2,255,177	8,915,453
2032	4,695,182	2,347,591	10,989,694
2033	4,887,584	2,443,792	13,320,962
2034	5,087,870	2,543,935	15,878,535
2035	5,296,364	2,648,182	18,681,361
2036	5,513,401	2,756,701	21,749,777
2037	5,739,333	2,869,666	25,105,607
2038	5,974,522	2,987,261	28,753,720
2039	6,219,350	3,109,675	32,730,987
2040	6,474,210	3,237,105	37,936,793
2041	6,739,514	3,369,757	43,632,301
2042	7,015,690	3,507,845	49,855,976
2043	7,303,182	3,651,591	56,634,838

